



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 20 өдөр

Дугаар А/89

Чингис хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.2, 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд хэрэгжих Хэнтий аймгийн Баянмөнх сумын инженерийн дулааны шугам сүлжээний угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга:	Ц.Чогсомжав	Аймгийн Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга:	Н.Үнэнбат	Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн
Гишүүд:	Б.Содбилэг	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилгын материал, үйлдвэрлэл, лаборатори хариуцсан мэргэжилтэн
	Ж.Даваасүрэн	Төрийн бус байгууллагын төлөөлөл
	Д.Оюун	Төрийн бус байгууллагын төлөөлөл

2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга /Ц.Чогсомжав/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

231010266